

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ**

№18/479

ШУС, НУС

2017

**СЭТГҮҮЛ ЗҮЙН ҮҮРГИЙГ ТОДОРХОЙЛОХ АРГА ЗҮЙН ЗАРИМ**  
**АСУУДАЛД**

М.Зулькафиль\*, Д.Оюунсүрэн\*\*

\*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, шинжлэх ухааны доктор (Sc.D)

\*\*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант

**Түлхүүр үг:** арга зүй, сэтгүүл зүйн үүрэг, институциональ түвшин, медиа бүтээгдэхүүн, “дөрөв дэх засаглал”, онтологийн функци, нийгмийн мэдээллийн харилцаа

**О**рчин үеийн сэтгүүл зүйн онолын хамгийн чухал бөгөөд тулгамдсан асуудлын нэг бол сэтгүүл зүйн үүргийг (функци) шинжлэх ухааны үндэстэй тодорхойлох асуудал юм. Учир нь энэ асуудлыг шийдвэрлэх нь сэтгүүл зүйн нийгмийн ач холбогдол, нийгмийн харилцааны системд түүний эзлэх байр, үүрэг роль, нийгмийн санаа бодолд нөлөөлөх, мэдээллийг түгээх, олон нийтийг гэгээрүүлэх, хүмүүжүүлэх салбар дахь стратеги зорилтуудыг тодорхойлох, тодруулахад нөлөөлдөг. Үүнээс үзэхэд үүргийн тухай асуудал бол сэтгүүл зүй хэмээх олон бүрэлдэхүүн хэсэгтэй, нарийн түвэгтэй системийн ажиллагаатай холбоотой хамгийн гол зүй тогтлуудыг илрүүлэхэд онцгой үүрэгтэй гэдэг нь тодорхой байна. Гэхдээ сэтгүүл зүйн үүргийг

тодорхойлох асуудалд эрдэмтэн судлаачид янз бүрийн өнцгөөс хандаж, янз бүрээр тайлбарлаж, тодорхойлж, томъёолсон байдаг нь түгээмэл юм. Энэ бол зөвхөн сэтгүүл зүйд төдийгүй нийгмийн шинжлэх ухааны бусад олон салбарт ажиглагддаг нийтлэг үзэгдэл юм.

Манай сэтгүүл зүйд ч “үүрэг”, “функци” гэсэн ойролцоо утгатай хоёр өөр ойлголтыг яг нэг л утгаар ойлгох явдал түгээмэл бөгөөд үүнийг цөөнгүй судлаачийн бүтээлээс ажиглаж болно. Уг нь олон улсын судлаачдын хүлээн зөвшөөрснөөр функци гэдэг нь үүргээс хамаагүй өргөн ойлголт. Функци өөртөө үүргээс гадна зориулалт, зорилго, зорилт, үйл ажиллагааны арга, хүрээ хэмээх хэд хэдэн утга санааг агуулдаг. Тиймээс бид энэ өгүүлэлд “үүрэг” гэдэг үгийг “функци” гэсэн арай өргөн утгаар авч хэрэглэсэн болохыг тэмдэглэе.

Өнөөдөр сэтгүүл зүйн онол дахь хамгийн маргаантай, нэг мөр болоогүй асуудал бол сэтгүүл зүйн үүргийн тухай асуудал гэж хэлж болно. Учир нь

судлаачид энэ асуудлыг судлах явцад хэд хэдэн арга зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийг оролддог нь ажиглагддаг.

Үүний нэг дэх хэсэг нь “сэтгүүл зүй” хэмээх ойлголтын өөрийг нь тодорхойлох асуудалтай холбоотой юм. Сэтгүүл зүй мөн чанарын хувьд хоёрдмол шинжийг агуулдаг бөгөөд институциональ түвшинд нэг төрлийн, субстанциональ (бодит байдлын хувьд) түвшинд өөр төрлийн үүргүүдийг гүйцэтгэдэг.

Хоёр дахь хэсэг нь “сэтгүүл зүй”, “ОНМХ” гэсэн ойлголтуудыг бараг ижил утгаар хэрэглэх явдалтай холбоотой юм. Энэ хоёр категорийн ялгааг сайн гаргаж чадаагүйгээс сэтгүүл зүйд шууд утгаар нь холбоогүй үүргийг (тухайлбал, реклам сурталчилгааны үүрэг г.м.) хүчээр хамааруулах зэрэг арга зүйн алдаа гаргахад хүргэсэн байдаг.

Гурав дахь хэсэг нь “функци” ба “ажиллагаа” гэсэн ойлголтуудыг хооронд нь хольж хутгах явдалтай холбоотой. Тиймээс зарим судлаач “дээрх ойлголтуудыг ялгаж зөв ойлгох шаардлагатай. Эс тэгвэл сэтгүүл зүйн үүргүүдийг болон тэднийг хэрэгжүүлэх арга замыг буруу тодорхойлоход хүргэдэг. Энэ нь онолын өөрийнхөө бүтээлч хандлага, шинийг эрэлхийлэх, олж илрүүлэх боломжийг хязгаарладаг”<sup>1</sup> гэж тэмдэглэснийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй юм.

Дөрөв дэх хэсэг нь судлаачдын сэтгүүл зүйн үүргийг тодорхойлох, тоог тогтоох шалгуур үзүүлэлт нь өөр, тодорхой бус байгаатай холбоотой бөгөөд үүнээс шатгаалан үүргүүдийг янз бүрээр ангилах хандлага газар авсан байдаг. Тийм хандлага манай сэтгүүл зүй судлаачдын бүтээлд ч түгээмэл ажиглагддаг.

**И**хэнх судлаач энэ ойлголтыг тодорхойлохдоо функци хэмээх үгийн уг гарал, утгыг (лат. *function*- үйл ажиллагааны үүрэг, зорилго, шинж чанар, үүргээ биелүүлэх) харгалзан үздэг. “Гадаад үгийн толь бичиг”-т “функци” гэдгийг “үйл ажиллагааны үүрэг, хүрээ; зорилго, роль”<sup>2</sup>, “Орос хэлний толь бичиг”-т “байгууллага, бие махбодиор үйлдэж буй ажил, үйл ажиллагааны үүрэг, хүрээ; зорилго, роль”<sup>3</sup>, “Монгол хэлний хураангуй тайлбар толь бичиг”-т “хамааран хувьсах хэмжигдэхүүн, ажиллагаа, үйл ажиллагаа”<sup>4</sup> гэж тодорхойлжээ. Зарим судлаач үгийн дээрх утга санааг харгалзан: “Сэтгүүл зүйн функци бол түүний үүргүүдийн болон биелүүлж байгаа зорилтуудын нийлбэр, нийгэм дэх идэвхтэй үйл ажиллагааны аргыг илэрхийлдэг”<sup>5</sup> гэж дүгнэсэн байдаг. Гэхдээ толь бичиг дэх товч тайлбар энэ ойлголтыг бүрэн дүүрэн илэрхийлж чадахгүй гэдэг нь ойлгомжтой. Тэр тусмаа бид сэтгүүл зүй хэмээх нарийн түвэгтэй үзэгдлийн үүргүүдийг тодорхойлохыг оролдож буй тохиолдолд тэднийг зөвхөн үүрэг эсвэл үйл ажиллагааны хүрээгээр хязгаарлах нь учир дутагдалтай юм. Энэ категорийн үгийн сангийн утгын хязгаарлагдмал байдлыг харгалзан судлаачид нэр томъёог арай өргөн хүрээнд авч үзээд, янз бүрийн утгаар тайлбарлахыг оролдсон байдаг. Ингэхдээ нэг дэх хэсэг нь “хэвлэлийн үүргийг нийгмийн амьдралын олон янз байдлыг, тэдний илрэх боломжийг харгалзан үзэх”<sup>6</sup> замаар тодорхойлохыг санал болгосон бол хоёр дахь хэсэг нь “сэтгүүл зүйн үүрэг нь нарийн түвэгтэй харилцан уялдаа холбоогоор нөхцөлдсөн байдаг бөгөөд тэд зөвхөн нэг шалтгаанаар хязгаарлагдахгүй.

Тиймээс сэтгүүл зүйн үйл ажиллагааны суртал нэвтрүүлэх, ухуулах, зохион байгуулах, гэгээрүүлэх, хүмүүжүүлэх зэрэг төрлийг функцийн нарийн түвэгтэй харилцан холбооны илрэл гэсэн утгаар авч үзэх хэрэгтэй”<sup>7</sup> гэдгийг онцлон тэмдэглэдэг. Тэгвэл гурав дахь хэсэг нь үүргийг нийгэм-улс төрийн, нийгэм-соёлын, эдийн засгийн зэрэг хүчин зүйлтэй холбон авч үзэхийг, дөрөв дэх хэсэг нь функцийг системд гүйцэтгэж буй элементүүдийн үүрэг гэсэн утгаар ойлгохыг санал болгодог байна.

Энэ мэтийн өөр өөр хандлага “функци” хэмээх категорийг янз бүрээр тайлбарлаж, тодорхойлоход хүргэсэн юм.

**Д**ээрх хандлагуудын дотор сэтгүүл зүйн үүргийг тодорхойлох системийн хандлага чухал байр эзэлдэг бөгөөд Оросын нэрт онолч Е.П.Прохоров сэтгүүл зүйг олон янзын үйл ажиллагааг агуулдаг систем гэж тодорхойлоод дараах зургаан үүргийг санал болгосон байдаг. Үүнд:

- “Сэтгүүл зүйн анхдагч үүрэг” болох коммуникатив буюу харилцааны үүрэг;
- “Сэтгүүл зүйн нийгэм дэх “дөрөв дэх засаглал”-ын үүрэг нь хамгийн бодитойгоор илэрдэг” зохион байгуулах;
- “Хүлээн авагчдын ертөнцийг үзэх үзэл ба үнэт зүйлсийн чиг баримжаа олж авах, хүмүүсийн ухамсар, туйлын хүсэл эрмэлзэл, зан байдлын үйлдлийн шалтгаанд нөлөө үзүүлэх” гэсэн хүчин чармайлттай холбоотой үзэл суртлын (нийгмийн чиг баримжаа олгох);
- Соёл-боловсролын үүрэг. Энэ нь “Нийгмийн соёлын нэг институт болохын хувьд соёлын үнэт зүйлсийг түгээх, сурталчлахад оролцох, хүмүүсийг дэлхийн соёлын шилдэг жишээ-

гээр хүмүүжүүлэх замаар хүний бүх талын хөгжилд нөлөөлөхөд оршдог”.

- “Хүлээн авагчдын янз бүрийн давхаргын сонирхолтой (аялал, цуглуулга, цэцэг ногоо тарих, шатар г.м.) холбоотой тэдний ердийн хэрэгцээг хангахад чиглэгдсэн” суртачилгаалавлагааны;
- Зугаацуулах (алжаал тайлах, ташаал авах, цэнгэх г.м.) юм.

Судлаачийн бодлоор “функциудийн орон зай”-г бүх талаар, харилцан холбоонд авч үзэх нь сэтгүүл зүйн нийгэмд гүйцэтгэх үүргийг ойлгоход нөлөөлөх аж<sup>8</sup>.

Оросын өөр нэг нөлөө бүхий онолч С.Г.Корконосенко сэтгүүл зүйн функцийг тодорхойлох нийгэм-үүргийн хандлагыг санал болгосон байдаг. Тэрээр “сэтгүүл зүйн нийгэм-үүргийн шинж чанар”-т онцгой ач холбогдол өгч үүнийг “олон нийтийн хэрэгцээ, тэдний хүсэн хүлээж буй зүйлтэй тохирсон хэд хэдэн нийгмийн үүргийг биелүүлэх” явдал буюу “сэтгүүл зүйн функци” гэж үзсэн байдаг<sup>9</sup>. Судлаач дээрх тодорхойлолтыг үндэслэн сэтгүүл зүйн:

- Үйлдвэр-эдийн засгийн;
- Мэдээлэл-харилцааны;
- Зохицуулагчийн;
- Үзэл суртал-оюуны гэсэн дөрвөн нийгмийн үүргийг санал болгожээ.

Зохиогчийн бодлоор хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийгэм-үүргийн шинж чанар түүний функцийг тодорхойлох асуудалтай шууд холбоотой юм. Учир нь сэтгүүл зүй “нийгмийн тодорхой системд өөрийн гэсэн өвөрмөц үүргийг гүйцэтгэдэг. Тухайлбал, нийгмийн талаас нь авч үзвэл гол үүрэг нь мэдээллийг цуглуулах, хуримтлуулах, хадгалах, боловсруулах, түгээх явдал юм. Оюун санааны талаас нь үзэл суртлын бүх институтуудад нийтлэг байдаг танин мэдүүлэх, гэгээрүү-

лэх, хүмүүжүүлэх, зохион байгуулах үүргийг гүйцэтгэдэг. Үүнээс үзвэл үүргийн хандлага ОНМХ-ийн үйл ажиллагааг бүхэлд нь тайлбарлах боломж олгодог. Гэхдээ энэ бол нийгмийн өвөрмөц институт болох сэтгүүл зүйн зөвхөн өөрийн үүргүүд биш бөгөөд хүсэл зоригоос нь үл шалтгаалан бий болсон үйл ажиллагааны хуулиуд, нөхцөл байдлын илэрхийлэл<sup>10</sup> юм. Хэдийгээр дээр дурдсан үндэслэлгүйгээр сэтгүүл зүйн нийгэмд гүйцэтгэх үүрэг, эзлэх байр, ач холбогдол, зорилгыг төсөөлөх боломжгүй гэдэг нь тодорхой боловч сэтгүүл зүйн өөрийн үүрэгт чухам юуг хамааруулж болох талаар судлаач хариулт өгөөгүй орхисон нь учир дутагдалтай юм.

Сүүлийн жилүүдэд сэтгүүл зүйн онолыг идэвхтэй судалж буй эрдэмтэн Т.В.Науменко үүнээс арай өөр үзэл бодолтой бөгөөд сэтгүүл зүй оюуны практик үйл ажиллагааны системийн элемент болохын хувьд түүний функц нь олон нийтийн ухамсарт нийгмийн субъектүүдийн хувьд цаг үеийн чухал үзэгдэл, баримтуудад өгсөн үнэлэмжийн хэлбэртэй бүтээгдэхүүнээр дамжуулан нөлөөлөхөд оршино<sup>11</sup> гэж дүгнэсэн байдаг. Энэ нь биднийг сэтгүүл зүй бол олон нийтийн ухамсарт өдөр тутмын бодит байдлын талаарх нийгмийн үнэлэмжийг нэвтрүүлэх, өөрөөр хэлбэл олон нийтийн ухамсарт өртсөн цаг үеийн үйл явдал, аль нэг нийгмийн бүлгийн ашиг сонирхлын хувьд чухал гэж үзсэн практик үйл ажиллагааны үр дүнд өгсөн үнэлэмжийн систем мөн гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Энэ бол сэтгүүлчийн үйлдлийг зүгээр нэг тоочин тайлбарлах (мэдээлдэг, таамаглал дэвшүүлдэг, сурталчилдаг, зугаацуулдаг г.м.) асуудалтай харьцуулахад сэтгүүл зүй

болон түүний үүргийн тухай яриаг арга зүйн нэлээд өндөр түвшинд авч үзэх шаардлагатай гэдгийг илэрхийлж буй нь хэрэг юм.

Сэтгүүл зүйн үүргийн тухай ийм ерөнхий дүгнэлт хийх нь зүй ёсны хэрэг. Учир нь сэтгүүл зүйн үүрэг нь зарим судлаачийн тэмдэглэсэнчлэн “хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийгмийн үндсэн хэрэгцээг хангахын тулд шийдвэрлэдэг хамгийн ерөнхий зорилтууд<sup>12</sup> юм.

**Х**эрэв бид сэтгүүл зүйг тодорхой систем гэж үзэх юм бол юуны өмнө түүний нийт системийн хүрээн дэх үүргийг тодорхойлох хэрэгтэй бөгөөд зөвхөн үүний дараа л системийн янз бүрийн элементэд (тухайлбал, редакци, сэтгүүлч, хүлээн авагч, сэтгүүлчийн эх бичвэр г.м.) хамаарах тусгай үүргүүдийг ялгаж үзэх шаардлагатай.

Профессор Е.В.Ахмадулины бодлоор “сэтгүүл зүйн системийн бүрэлдэхүүн хэсэг болгон системд гүйцэтгэх тодорхой үүрэгтэй бөгөөд энэ нь түүнийг оршин тогтнох, “амьдрах” боломжоор хангадаг. Гэхдээ бүрэлдэхүүн хэсгүүдийн үүрэг нь нийт системийн үүрэгт “захирагдаж”, түүний төлөө “ажилладаг”. Харин бүрэлдэхүүн хэсгүүдийн үүргүүдийн нийлбэр системийн ерөнхий үүрэг болж чадахгүй. Эсрэгээр бүрэлдэхүүн хэсгүүд өөрсдийн үүргүүдийн дотроос сэтгүүл зүйн системийн төлөө ажиллах чадвартай тэр хэсгүүдийг шилжүүлэх замаар өөртөө системийн үүргийн шинжийг агуулж, тэдний нөлөөгөөр өөрчлөгдөж байдаг<sup>13</sup> ажээ.

Энэ бол үнэхээр хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй зөв дүгнэлт юм. Учир нь сэтгүүл зүйн түүхэн хөгжлийн явцад түүний анхны үүргүүд зөвхөн өргөжиж, баяжин гүнзгийрэх төдийгүй,

улс төр, эдийн засаг, нийгэм, технологийн зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан цөөнгүй шинэ үүргийг гүйцэтгэх болсон. Сэтгүүл зүй орон зай, цаг хугацааны маш өргөн хүрээнд үйлчилдэг нийгмийн системийн нэг болохын хувьд түүний үйл ажиллагааны онцлог нь тухайн нийгэмд үйлчилж буй хууль эрх зүйн актуудаас ихээхэн шалтгаалдаг. Тиймээс аливаа системийн үүргийг нэлээд өргөн хүрээний системийн бүрэлдэхүүнд багтдаг тусгай дэд системүүдийн хөдөлгөөн, үйлдлийн аргын хувьд авч үзэх нь арга зүйн хувьд зөв юм. Аливаа үүрэг тухайн системийн өвөрмөц онцлогийг тодорхой хэмжээгээр илэрхийлж чаддаг. Хэрэв системийн үйл ажиллагаа, үйлдлийн аргын мөн чанарыг ойлгоогүй тохиолдолд түүний ямар ч бүрэлдэхүүн хэсгийг зөв ойлгох боломжгүй юм. Учир нь “системийн үйл ажиллагааны, өөрөөр хэлбэл үүрэг нь бүрэлдэхүүн хэсгүүдийн бүтэц, харилцан нөлөөлөл, уялдаа холбоогоор тодорхойлогддог. Аливаа бүрэлдэхүүн хэсэг тодорхой үүргийг биелүүлэх замаар өөрийн гэсэн онцлогтой болдог”<sup>14</sup>.

**Ж**ишээ болгон бүх засаг төрийн эрх мэдэл коммунист намын даргын гарт төвлөрсөн тоталитар дэглэмтэй нийгмийн сэтгүүл зүйн үүргийг авч үзье. Тийм улс оронд сэтгүүл зүйн үүрэг нь ямар байж болох вэ? 1990-ээд оноос өмнөх БНМАУ-ын сэтгүүл зүйн хамгийн гол үүрэг нь коммунист намын бодлогыг ухуулах, сурталчлах явдал байсан. Энд сэтгүүл зүйг ноёрхож буй бүлгийн үзэл суртлын зэвсэг, мөн бусад хэрэгслүүдийн хамт олон нийтэд үзэл суртын нөлөө үзүүлэх арга гэж үзэж байлаа.

Ардчилсан нийгэмд сэтгүүл зүйн үндсэн үүрэгт төр засгийн үйл

ажиллагаанд хяналт тавих (чухам энэ утгаар нь сэтгүүл зүйг “дөрөв дэх засаглал” гэж үздэг), нийгмийн янз бүрийн давхаргын төлөөллүүдийн хооронд нийгмийн яриа, хэлэцүүлэг өрнүүлэх, өдөр тумын амьдралын бодит дүр зургийг бүтээх зэрэг олон үүргийг багтааж болно. Үүнээс үзэхэд “хэрэв тодорхой формаци, эрин үе, ангийн сэтгүүл зүйн үүргийг ойлгох зорилт тавьсан тохиолдолд янз бүрийн үзэл суртал, улс төрийн систем, соёл болон ангийн шаардлагуудыг харгалзан үзэх, функцийг хэр зэрэг ухамсартайгаар биелүүлж байгааг илрүүлэх шаардлагатай юм”<sup>15</sup>.

Бид дээр дурдсан жишээнүүдээс сэтгүүл зүйн улс төрийн хүрээн дэх зөвхөн цөөн хэдийг онцлон авч үзлээ. Нийгмийн оюуны болон бусад салбарт сэтгүүл зүйн өмнө өөр олон зорилт тавигдах нь мэдээж. Энэ нь эдийн засгийн салбарт удирдах үүрэг, оюуны салбарт үзэл суртлын, боловсролын салбарт нийгэмшүүлэх, гэгээрүүлэх, хүмүүжүүлэх, амралт чөлөөт цагийн хувьд зугаацуулах, хөгжөөх гэх мэтээр үргэлжлүүлэх боломжтой. Ийм үүргийн тоо, хэмжээ нийгэм дэх сэтгүүл зүйн оршин тогтнох түүхэн, улс төрийн нөхцөл байдлаас, ОНМХ-ийн технологийн хөгжлийн түвшнээс, сэтгүүл зүйн өөрийн боломжоос шалтгаалан өрчлөгдөж болно. Тиймээс судлаачдын “үүргүүд түүхэн шинжтэй, тэдний нийгэмд өрнөж байгаа үйл явц, өөрчлөлттэй салшгүй уялдаа холбоотой бөгөөд тэднийг сэтгүүл зүй өөрөө тухайн нийгэмд тодорхой хэмжээгээр бий болгодог. Мөн тэдэнд системийн онцлогийг илэрхийлдэг шинэ үүргүүд, тэр ч байтугай илүү их зорилтуудыг үүсгэх дотоод чадвар, боломж байгаа нь ажиглагддаг”<sup>16</sup> гэж тэмдэлэсэн нь санамсаргүй зүйл биш юм.

Сэтгүүл зүй өөрийнхөө оршин тогтнох 400 гаруй жилийн туршид аливаа нарийн түвэгтэй системийн үзэгдлийн нэгэн адил зөвхөн өөрт нь тохирсон нийгмийн функциудтэй болж чадсан. Зөвхөн энэ функциудын тусламжтайгаар сэтгүүл зүйн нийгэмд гүйцэтгэх үүрэг, түүний янз бүрийн институт, хувь хүн, хэсэг бүлэг зэрэг бүх субьекттэй харьцах харилцааны мөн чанар, сэтгүүл зүйн нийгмийн үйл явц дахь оролцоо, үйл ажиллагааны үр дагавар, нийгмийн зорилтыг биелүүлэх аргууд, олон нийтийн сэтгүүл зүйгээс хүсэн хүлээж буй зүйл, тэдний нийгмийн үүргийн талаарх төсөөллийг тодорхойлж болно.

“Сэтгүүл зүйн нийгмийн функци” гэдэг категорийг сэтгүүл зүйн онолд оруулсан судлаач бол Г.Першке. Тэрээр сэтгүүл зүйн олон янзын үүргийн дотроос нийгмийн амьдралд оролцох өвөрмөц онцлогийг илэрхийлж чадахуй үзэл суртлын, улс төрийн, соёлын, нийгмийн үүргийг тэргүүн зэрэгт тавьсан байдаг<sup>17</sup>.

Үзэл суртлын үүрэг. Үзэл суртал бол үзэл санааны тухай сургаал, өөрөөр хэлбэл мөн чанарын хувьд эерэг ч, сөрөг ч нэмэлт утгыг илэрхийлэхгүй. “Үзэл суртал гэдэг нь нийгмийн тодорхой бүлгийн үйл ажиллагааны туршлага, амьдралын нөхцөлөөс үүдэн бий болдог онол, үзэл санаа, эдгээрт үндэслэсэн үйл ажиллагааны удирдамжийг багтаасан үзэл бодлын систем юм. Тухайн үзэл суртал нь нийгмийн аль нэг бүлгийн өвөрмөц, онцгой ашиг сонирхол, хүсэл эрмэлз-

лийн тусгал болж өгдөг бөгөөд тэр бүлгийнхээ эрх ашгийг хамгаалах үүрэгтэй”<sup>18</sup> юм. Тиймээс сэтгүүл зүйн үзэл суртлын үүрэгт:

- Хүмүүсийн улс төрийн, эдийн засгийн, эрх зүйн, ёс зүйн, ёс суртахууны, гоо зүйн, философийн зэрэг нийгмийн амьдралын янз бүрийн үзэгдэлд хандах төсөөлөл, ойлголт, үнэлэмжийг төлөвшүүлэх;
- Үзэл санааны, улс төрийн болон бусад үзэл бодлыг сурталчлах;
- Олон нийтийн санаа бодлыг төлөвшүүлэх;
- Олон нийтийн ухамсарт нөлөөлөх үйл ажиллагаа нь багтдаг.

Сэтгүүл зүйн улс төрийн үүрэгт:

- Нийгэм-улс төрийн үйл явцыг удирдахад хяналт тавих, зохицуулах зорилгоор оролцох;

Нийгмийн үүрэгт:

- Хүмүүсийг хүлээн авагчдын дунд болон тодорхой хүрээлж буй орчинд дасан зохицоход нөлөөлөх;
- Тодорхой нийгмийн орчин болон нийгмийн харилцааны системд нийгэм-соёлын туршлага, дадал, мэдлэг, хэм хэмжээ, үнэт зүйлс, уламжлалыг эзэмшихэд нөлөөлөх;

Зохион байгуулах үүрэгт:

- Нийгмийн практикт, нийгмийн институт, бүлэг, нэгдэл болон хувь хүмүүсийн зан байдалд тодорхой өөрчлөлт гарахад нөлөөлөх зэрэг болно.

Үүнээс үзэхэд янз бүрийн системээр тодорхойлогддог нийгмийн функциудын үр дүнд сэтгүүл зүй олон

«

***Сэтгүүл зүй өөрийнхөө оршин тогтнох 400 гаруй жилийн туршид аливаа нарийн түвэгтэй системийн үзэгдлийн нэгэн адил зөвхөн өөрт нь тохирсон нийгмийн функциудтэй болж чадсан***

»

нийтийн ухамсарт нөлөөлөх замаар нийгмийн харилцааны системд томоохон байр эзэлдэг. Харин судлаачид сэтгүүл зүйн өөрийн функцид онтологийн, гносеологийн, аксиологийн, мэдээлэл-харилцааны үүргийг оруулдаг нь зүй ёсны хэрэг юм. Учир нь энэ үүргүүд сэтгүүл зүйн нэгдмэл систем болох онцлогийг бүрэн илэрхийлж чаддаг юм.

**С**этгүүл зүйн онтологийн үүрэг. Онтологи (грекийн *ontos*-мөн чанар, *logos*- сургаал) бол ахуй болон түүний төрөл, шинжүүдийн талаарх философиин сургаал юм. Тэгвэл сэтгүүл зүйн хувьд онтологи нь сэтгүүл зүйн мөн чанар, түүний нийгмийн ертөнцөд орших хэлбэрүүд, сэтгүүл зүй дэх ертөнцийн дүр зургийн тусгал, нийгэмд оршин эргэлдэж буй янз бүрийн мэдээллийн урсгалын үүсэл, түгээл-тийн хууль, зүй тогтлын талаарх сургаал гэж ойлгож болно. Бидний бодлоор энэхүү онтологийн асууд-луудыг боловсруулах явцад сэтгүүл зүйн нийгмийн үзэгдэл болох хамгийн гол, хамгийн ерөнхий шинж чанаруудыг эрж хайх боломжтой юм. Сэтгүүл зүйн онтологийн зорилт бол нийгмийн ертөнцийн нэгдмэл дүрийг бүтээх, үү-гээр дамжуулан ертөнцийг үзэх үзлийн чиг баримжааны системийн үүргийг гүйцэтгэх онцлогтой.

Сэтгүүл зүй дараах үүргүүдийг биелүүлэх замаар хүмүүст нийгмийн чиг баримжаа олж авахад тусалдаг онцлогтой. Үүнд:

- Гадаад ертөнцийн мэдээллийн загварыг бүтээх;
- Хүрээлж буй ертөнцийн тухай төсөөллийг тусгай баримтаас эхлэн глобаль хуулиуд хүртэлх, хувь хүний тухай санаа бодлоос эхлээд хүний мөн чанар, хүн төрөлхтний хувь заяаг ойлгох хүртлэх бүхий төрлийн

илэрлүүдээр нь дамжуулан төлөвшүүлэх;

- Бодит байдлыг үнэн зөв тусгах;
- Хүмүүст хүсэн хүлээж буй ирээдүйн болон түүнд хүрэх арга замын талаарх төсөөллийг төлөвшүүлэх зэрэг юм.

Гносеологийн буюу танин мэдүүлэх үүрэг. Сэтгүүл зүйг гносеологийн (грекийн *gnosis*-мэдлэг, *logos*-сургаал, танин мэдэхүйн онолыг судалдаг философиин салбар) буюу танин мэдэхүйн онолын үүднээс авч үзвэл бодит байдлыг таньж мэдэх тусгай хэлбэрт хамааруулж болно. Танин мэдэхүйн энэ төрлийн гол онцлог нь рациональ болон уран сайхны аргуудын хослол байдаг оршдог. Судлаачийн онцлон тэмдэглэснээр “сэтгүүл зүйн нийгмийн зорилго нь хүрээлж буй нийгмийн болон байгаль орчныг таньж мэдэх, хүлээн авагчдад олж авсан мэдээллийг болон хуримтлагдсан соёлын туршлагыг дамжуулах, материаллаг болон оюуны дүр зургийг тусгах, хүлээн авагчдад нийгмийн чиг баримжаа олгоход туслахад орших”<sup>19</sup> тул сэтгүүл зүйн гносеологийн функцид:

- Хүмүүсийн нийгмийн ертөнцийн объектүүд, тэдний харицаа холбоог болон түүнд үйлчилж буй нийгмийн ахуйн хуулиудыг таньж мэдэх;
- Хүмүүсийн нийгмийн практикийг таньж мэдэх, нэгтгэн дүгнэх;
- Мэдлэгийн янз бүрийн хүрээ, түвшнийг баяжуулах, хөгжүүлэх явдал багтах юм.

Сэтгүүл зүйн аксеологийн буюу нийгмийн үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх үүрэг. Философиин толь бичгүүдэд “аксиологи” (грекийн *axios*-үнэт зүйл, *logos*-сургаал, үг, ойлголт) хэмээх нэр томъёог үнэт зүйлсийн тухай сургаал, хүний үйл ажиллагааны

чиглэл, хандлага, үйл хөдлөлийн шалтгааныг тодорхойлдог ерөнхий зарчмуудын тухай философийн онол гэж тодорхойлсон байдаг. Субъектийн талаас үнэт зүйлд хандах хандлага бол үндсэн хоёр аргаар хэрэгждэг: нэг талаар, үнэлэлт өгч буй объектийг *үнэт зүйлд хамааруулах*, нөгөө талаар түүнийг *тунгаан ойлгох* явдал юм. Судлаачдын тэмдэглэснээр үнэт зүйл гэдэг бол ямар нэгэн үндэслэлээр аливаа зорилго эсвэл үзэгдэлд тодорхой утга өгч буй тэр зүйл мөн. Үнэт зүйл дангаараа ахуй болж чадахгүй, зөвхөн утга агуулдаг. Тэд санаа зориг, зорилго руу хандсан шаардлагуудын утгыг илэрхийлдэг. Тиймээс үнэт зүйлсийг зөвхөн ёс суртахууны үнэт зүйлстэй, аксиологийг зөвхөн ёс зүйн үнэт зүйлстэй хамаатай зүйл гэж ойлгож болохгүй. Сэтгүүл зүйд байвал зохих ёс суртахууны шаардлага, хэм хэмжээг үнэт зүйлсийн шаардлагатай ижил түвшинд авч үздэг. Нэг талаар сэтгүүлч нийгэмд хэрэгтэй, нөгөө талаар түүний бүтээл, олон талт бүтээлч үйл ажиллагаа нь бас л нийгэмд хэрэгтэй. Энэ утгаараа сэтгүүл зүй хүний оюуны амьдралын чухал суваг болох замаар нийгмийн ач холбогдол бүхий үнэт зүйлсийн үүргийг гүйцэтгэдэг онцлогтой юм.

Сэтгүүл зүй нийгмийн амьдралын улс төрийн, эдийн засгийн, эрх зүйн, ёс зүйн, ёс суртахууны, философийн зэрэг янз бүрийн үзэгдэлд хандах үнэт зүйлсийн хандлагыг төлөвшүүлдэг. Тийм учраас сэтгүүл зүйн аксеологийн функци нь:

- Нийгэмд соёлын үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх, хүмүүсийн дэлхий нийтийн соёлын жишээгээр хүмүүжүүлэх, эцэст нь бүтээлч бие хүнийг төлөвшүүлэхэд;

- Харилцаа, харилцан нөлөөлөл, өөрийгөө боловсронгуй болгох явцад хүрээлж буй ертөнцөд гоо зүй, шашин болон бусад талаар үнэлэмж өгөх харилцааг төлөвшүүлэхэд;
- Иргэдийн үнэлэмж өгөх баримжааг бий болгоход чиглэгддэг.

**С**этгүүл зүйн мэдээлэл-харилцааны үүрэг. Мэдээлэл-харилцааны үүрэг бол сэтгүүл зүйн системийн мөн чанарыг тодорхойлдог хамгийн гол шинж, тодруулж хэлбэл өвөрмөц нийгмийн үзэгдэл бөгөөд түүний эргэн тойронд энэ систем бүрэлдэн тогтсон байдаг. Энэ үүрэг нэгдмэл хоёр шинжтэй, учир нь мэдээлэлгүйгээр харилцаа орших боломжгүй. Өөрөөр хэлбэл сэтгүүл зүйн харилцааны хамгийн гол хэрэгсэл мэдээлэл бөгөөд мэдээлэлгүйгээр зөвхөн сэтгүүл зүйн төдийгүй нийгмийн ямар ч харилцааг төсөөлөх боломжгүй гэдэг нь тодорхой. Тиймээс сэтгүүл зүй энэ функцийн хүрээнд:

- Нийгмийн үйл ажиллагааны үйл явцад хүлээн авагчдын хооронд мэдээлэл солилцох, харилцахад нөлөөлөх;
- Нийгэмд болон дэлхий дахинд болж байгаа үйл явдал, нийгмийн амьдралын талаар мэдээлэх;
- Нийгмийн харилцаа, харилцан яриа өрнүүлэх үндсийг бүрдүүлэх;
- Хүмүүст өөрсдийн нийгмийн үүргийг хэрэгжүүлэхэд туслах зэрэг үүрэгтэй юм.

Энэ бүхнээс үзэхэд нийгмийн системтэй шууд холбоотой бий болсон сэтгүүл зүйн нийгмийн функциуд болон сэтгүүл зүйн өөрийн мөн чанараас урган гарсан функциуд нь түүний нийгэмд гүйцэтгэх үүрэг, зорилго, ач холбогдлыг тодорхойлдог байна. Сэтгүүл зүйн нийгмийн функциуд нь гол төлөв улс төр, эдийн засаг, соёл,



технологийн болон бусад хүчин зүйлээс шалтгаалдаг. Сэтгүүл зүйн өөрийн функциуд нь (онтологийн, танин мэдэхүйн, үнэт зүйлсийг түгээх, мэдээлэл-харилцааны) бүхэлдээ хүмүүсийн мэдээллийн хэрэгцээг хангахад чиглэгддэг. Нийт системийн хүрээнд үйлчилдэг эдгээр функциуд нь сэтгүүл зүйн тусгай үүргүүдийн хүрээнд бас илэрч болно.

Сэтгүүл зүй өөрөө тодорхой систем учраас янз бүрийн элементээс бүрддэг. Тэгвэл бид функци гэдгийг системийг болон түүний элементүүдийг хөдөлгөөнд оруулж, түүний хөгжил, хөдөлгөөн, өөрчлөлтийг илэрхийлдэг тусгай үйл ажиллагааг гүйцэтгэх, хэрэгжүүлэх үйлдэл гэж ойлгож болно. Үйл ажиллагааны тийм субъектуудад сэтгүүлч, редакцийн хамт олон, эцэст нь нийгмийн зохион байгуулалттай бүтэц болох ОНМХ-ийг оруулдаг. Олон нийтийн мэдээллийн үйл ажиллагааны дээрх субъект болгон өөрийн гэсэн үүрэг, зорилготой юм.

Сэтгүүл зүй бол нийгмийн бараг бүх системтэй холбоотой, өөрийн гэсэн бүтэц бүрэлдэхүүнтэй нэлээд өндөр түвшинд хөгжсөн систем мөн. Тиймээс сэтгүүл зүй систем болохын хувьд дараах бүтэцтэй юм. Үүнд:

- Макро түвшин буюу ОНМХ буюу тогтмол хэвлэл, радио, телевиз, сүлжээний мэдээллийн хэрэгслүүд;
- Мезо түвшин буюу медиа үйлдвэрүүд;
- Микро түвшин буюу сэтгүүлчид юм.

Сэтгүүл зүйн үүрэг-үйл ажиллагааны бүтцийн онцлог нь янз бүрийн түвшнээс тогтдог бөгөөд тэдний хооронд зохицуулах, захирагдах харилцаа үйлчилдэгт оршино. Тиймээс асуудлын гол нь бүтцийн аль нэг элементийн үүргийн тоонд бус, харин тэдний мөн чанарт байдгийг анхаарах нь юу юунаас чухал юм. Бүх түвшний мөн чанарыг тодорхойлдог зүйл бол сэтгүүл зүйн үйл ажиллагааны судлагдахууны үндэс байх учиртай. Энэ бол макротүвшинд ОНМХ-ийн нийгмийн ач холбогдолтой мэдээллийг цуглуулах, олшруулах, түгээх үйл ажиллагаа юм. Энэ мэдээ-

лэл танин мэдүүлэх, зугаацуулахаас эхлээд лавлах хүртэлх, баримтат мэдээллээс уран сайхны хүртэлх олон шинжийг агуулдаг нь тодорхой. Тиймээс ОНМХ нийгмийн зохион байгуулалттай бүтэц болохын хувьд сэтгүүл зүйн функцид шууд холбоогүй үүргүүдийг биелүүлдэг нь энгийн үзэгдэл байдаг.

«

*Сэтгүүл зүй өөрөө тодорхой систем учраас янз бүрийн элементээс бүрддэг. Тэгвэл бид функци гэдгийг системийг болон түүний элементүүдийг хөдөлгөөнд оруулж, түүний хөгжил, хөдөлгөөн, өөрчлөлтийг илэрхийлдэг тусгай үйл ажиллагааг гүйцэтгэх, хэрэгжүүлэх үйлдэл гэж ойлгож болно. Үйл ажиллагааны тийм субъектуудад сэтгүүлч, редакцийн хамт олон, эцэст нь нийгмийн зохион байгуулалттай бүтэц болох ОНМХ-ийг оруулдаг. Олон нийтийн мэдээллийн үйл ажиллагааны дээрх субъект болгон өөрийн гэсэн үүрэг, зорилготой юм*

»

ОНМХ-ийн функцийг боломж асар их, маш өргөн хүрээг хамардаг учраас тэднийг үйл ажиллагааны янз бүрийн чиглэлээр ангилж болно. Тухайлбал:

- Үйлдвэрлэл-эдийн засгийн;
- Удирдан зохицуулах;
- Зар сурталчилгаа-лавлагааны;
- Нэгтгэн зохион байгуулах;
- Хүмүүжил-үзэл санааны;
- Соён гэгээрүүлэх;
- Алжаал тайлах, зугаацуулах гэх зэргээр үргэлжлүүлж болно.

Медиа байгууллагууд бол сэтгүүлчдээс бүрддэг бүтээлч бүлгээс гадна медиа бүтээгдэхүүнийг бэлтгэн гаргадаг, түгээдэг техник ажилтнуудыг багтаадаг редакцийн хамт олон юм. Тэдний үндсэн үүрэг нь:

- Медиа бүтээгдэхүүнийг эфирт гаргах, хэвлэх, түгээх зорилго бүхий мэдээллийн үйлдвэрлэлийг хэрэгжүүлэх;
- Редакцийн хамт олны үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах;
- Медиаүйлдвэрлэлийн үйл ажиллагааны санхүүгийн асуудлыг зохицуулахад оршдог.

Тэгвэл сэтгүүлчид зохиогчийн (жинхэнэ эх бичвэрийг бүтээх), редакторын (сэтгүүлчийн материалыг нийтлэх, нэвтрүүлэхэд бэлэн болгох), зохион байгуулалтын (редакцийн янз бүрийн арга хэмжээг зохион байгуулах) үүрэг хүлээдэг юм.

Нэлээд нарийн түвэгтэй систем болох сэтгүүл зүйн бүтцийн янз бүрийн элементийг авч үзэх явцад системийн элемент болгон нэгэн зэрэг түүний ерөнхий шинжийг агуулдгийг амархан ажиглаж болно. Тухайлбал, ОНМХ зөвхөн нийгмийн ач холбогдол бүхий мэдээллийг түгээхээс гадна дэлхий ертөнцийн мэдээллийн дүр зургийг

бүтээх, хүмүүснийгэмд дацан зохицоход чухал үүрэг гүйцэтгэдэг, харилцааны үйл явцыг зохион байгуулах зэрэг янз бүрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог. Үүний зэрэгцээ бүрэлдэхүүний хэсэг болгон өөрийн гэсэн онцлог шинжтэй бөгөөд тэднийг нэгэн зэрэг системийн ерөнхий шинжид оруулах боломжгүй юм. Тухайлбал, сэтгүүлчийн хянан найруулах үүргийг сэтгүүл зүйн системийн ерөнхий шинжтэй холбох нь учир утгагүй юм.

**Д**ээр дурдсан санаа бодлыг нэгтгэн үзвэл бид нийгмийн харилцааны систем дэх сэтгүүл зүйн үүрэг, зорилгыг илэрхийлдэг “функци” хэмээх ойлголтын мөн чанарын талаар тодорхой төсөөлөлтэй болсон гэсэн дүгнэлтэд хүрч болох юм. Энэ функциудын өвөрмөц онцлогийг илрүүлэхийн тулд бид зөвхөн сэтгүүл зүйн ерөнхий функциудээс гадна бүтцийн элементүүдийн үүргийг илэрхийлдэг зөвхөн сэтгүүл зүйн өөрт нь байдаг үүргүүдийг тодорхойлохыг оролдлоо. Энэхүү бүх функцийн ачаар нэгдмэл систем болох сэтгүүл зүйн бүтцийн элементүүдийн үйл ажиллагаа хэвийн явагдах боломж бүрддэг. Сэтгүүл зүйн функциуд хоорондоо нэлээд нарийн түвэгтэй харилцан уялдаа холбоонд оршдогийг дээр өгүүлсэн дүн шинжилгээний явцаас амархан ажиглаж болох бөгөөд чухам энэ онцлогийн ачаар сэтгүүл зүй бусад янз бүрийн нийгмийн институттай холбоотой байдаг юм. Сэтгүүл зүйн функцийг онцлог, чиглэлээр дамжуулан түүний аливаа түүхэн үе дэх үүрэг роль, эзлэх байр, ач холбогдлыг тодорхойлж болно. Сэтгүүл зүйн функциудыг үнэн бодитой, шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлж, үнэлж чадах нь тухайн системд үйлчилж буй дотоод зүй тогтлуудыг илрүүлэх боломж олгодог.

### Ишлэл

- 1 Науменко Т.В. Функция журналистики и функция СМИ // <http://credonew.ru/content/view>
- 2 1985. Словарь иностранных слов. М. с.543.
- 3 Ожегов С.И. 1973. Словарь русского языка. М. с.789.
- 4 2009. Монгол хэлний хураангуй тайлбар толь (Эрх. Б.Баярсайхан). УБ. х.760.
- 5 Прохоров Е.П. 2000. Введение в теорию журналистики. М. с.44.
- 6 Липовченко Н.Н. 1985. Очерк теории журналистики. М. с.25.
- 7 Першке Г. 1993. Журналистика как отрасль духовного производства // Основные понятия теории журналистики (новые подходы к проблеме) / Под. Ред. Я.Н.Засурского. М. с.84.
- 8 Прохоров Е.П. Указ. соч., с.44-47.
- 9 Корконосенко С.Г. Основы теории журналистики. М., 2001. с.162.
- 10 Там же. с.177.
- 11 Науменко Т.В. Указ. соч.
- 12 Моисеев В. 2002. Журналистика и журналисты. Киев. с.51.
- 13 Ахмадулин Е.В. 2006. Краткий курс теории журналистики. Ростов-на-Дону. с.205.
- 14 Науменко Л.К., Югай Г.А. 1968. “Капитал” К.Маркса и метод исследования. М. с.35-36.
- 15 Першке Г. Указ. соч., с.86.
- 16 Моисеев В. Указ. соч., с.56.
- 17 1995. Журналистика и социология /Под ред. И.Д.Фомичевой. М. с.131.
- 18 Баяраа С нар. 2006. Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь. УБ. х.128.
- 19 Короченский А.П. “Пятая власть?”. Феномен медиакритики в контексте информационного рынка. Ростов-на-Дону. 2002. с.47.
2. Баяраа С нар. 2006. Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь. УБ.
3. Журналистика и социология /Под ред. И.Д.Фомичевой/. М. 1995.
4. Корконосенко С.Г. Основы теории журналистики. М., 2001.
5. Короченский А.П. “Пятая власть?”. Феномен медиакритики в контексте информационного рынка. Ростов-на-Дону. 2002.
6. Липовченко Н.Н. 1985. Очерк теории журналистики. М.
7. Моисеев В. 2002. Журналистика и журналисты. Киев.
8. Монгол хэлний хураангуй тайлбар толь (Эрх. Б.Баярсайхан). УБ. 2009.
9. Науменко Т.В. Функция журналистики и функция СМИ // <http://credonew.ru/content/view>
10. Науменко Л.К., Югай Г.А. 1968. “Капитал” К.Маркса и метод исследования. М.
11. Ожегов С.И. 1973. Словарь русского языка. М.
12. Першке Г. 1993. Журналистика как отрасль духовного производства // Основные понятия теории журналистики (новые подходы к проблеме) / Под. Ред. Я.Н.Засурского/. М.
13. Прохоров Е.П. 2000. Введение в теорию журналистики. М. с.44.
14. Словарь иностранных слов. М. 1985.

### Резюме

В статье рассматриваются некоторые теоретико-практические вопросы функции журналистики. Автор считает, что вопрос о функциях предполагает раскрытие определённых закономерностей, связанных с функционированием такой сложной и многокомпонентной системы, как журналистика. Автор опираясь на теоретические выводы исследователей и практические примеры СМИ показывает особенности общественных функций журналистики, собственных журналистских функций и функций медиапредприятия.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Ахмадулин Е.В. 2006. Краткий курс теории журналистики. Ростов-на-Дону.